

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
01 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

2023.01.30

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Сумын 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлуулж, байгууллага, мэргэжилтнүүдэд хүргэсэн.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, ЗДТГ хамтран Монгол улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойн өдрөөр иргэд, төрийн албан хаагчдын дунд “Үндсэн хуулиа хэн сайн мэдэх вэ” цахим АХА тэмцээн зохион байгуулж 53 хүн оролцсон.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, сумын засаг дарга нар отрын нутгийн бүх өрхөөр явж, өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, шаардлагатай эм, хүнсний бүтээгдэхүүнийг хүргэж өгсөн.

Мөн хилийн зурваст орсон сумын малчдын малыг татах ажилд засаг дарга, багийн нар оролцсон.

Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн хурлыг сумын засаг даргын захирамжаар хилийн цэргийн 0184 дүгээр ангитай хамтран зохион байгуулж, 2023 онд хамтран ажиллах төлөвлөгөөг баталсан.

Цэргийн үүрэгтнүүдийн 2023 оны судалгааг нэгтгэн цэргийн штабт хүргэсэн.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.

01 дүгээр сарын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь гаргаж төрийн сангийн хэлтэст өгсөн.

2022 оны жилийн эцсийн өрх, хүн ам, малын нэгдсэн тооллогыг зохион байгуулж, дүн мэдээг статистикийн газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт сумын 2022 оны санхүүгийн тайланг хүлээлгэн өгсөн.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:

“Эрх зүйн хөтөч” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тамгын газрын 5 албан хаагчийг эрх зүйн хөтөчөөр бэлтгэн ажилуулах гэрээг боловсруулж, Хууль зүйн хэлтэсийн даргатай байгуулсан.

Тамгын газрын албан хаагчдад шинээр мөрдөгдөж байгаа Зөвшөөрлийн тухай хуулиар сургалт, мэдээлэл зохион байгуулсан.

Дөрөв.Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төвөөс хамтран оторын нутгийн өрхөөр явж эрүүл мэндийн үзлэг, төрийн мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан.

Соёлын төвөөс Үндсэн хуулийн өдрөөр үндэсний уламжлалт тоглоом наадгайг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хаагчдын дунд “Шаагайн наадгай-г Шагай няслах, Шагай шүүрэх, Морь уралдуулах гэсэн төрлөөр зохион байгуулж 49 хүн оролцсон.

Хүүхдийн цэцэрлэгээс оторын бүс нутагт өвөлжиж байгаа алслагдсан өрх, 5-аас дээш хоногийн чөлөө, акттай байгаа хүүхдийг тэгш хамруулах, сургалтын тасралтгүй байдлыг хангаж “Ном тоглоом”-ын багцыг шинээр нэмэгдүүлж хүргэн, зайнаас болон гэрээр суралцах боломжоор хангасан.

Цэцэрлэгийн багш, ажилчдыг ёс зүйн болон ур чадварыг дээшлүүлэх цахим сургалтуудад хамруулсан.

“Би залуу багш” хөтөлбөрийн хүрээнд “Сайн сайхан зан чанарыг хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 160 хүүхдийн суудалтай бага сургуулийн хичээлийн байрыг хүлээн авч, ашиглалтанд оруулав. /1.700.000.000 төгрөг/

Сумын залуучуудын холбооноос байгууллага, ААН, иргэдийн дунд “Цасны баяр” арга хэмжээг зохион байгуулсан.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцөөс малчин өрхүүдэд 80 тн өвс, 6 тн тэжээлийг 1 өрхөд 5 боодол өвс, 1 шуудай тэжээл хуваарилан олгосон. / 1 боодол өвс 5000 төгрөг, 1 шуудайг тэжээл 10000 төгрөгөөр олгосон/

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ